



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот


### ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газраас санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/145 дугаар тушаалаар баталсан “ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 5.6.2, 7.6 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газраас 2022-2023 онд санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Санхүүжилт олгох төслийн сонгон шалгаруулалтыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулахыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл (Д.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.НАМНАН

367040804



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн  
А/157 дугаар тушаалын хавсралт

**ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газраас  
санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын удирдамж**

**Зорилго:**

ШУТИС-ийн судалгаа, инновацийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц судалгааны төслүүдийг сонгон шалгаруулж, 2022-2023 онд санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

**Төслийн төрөл:**

ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газраас 2022-2023 онд хэрэгжүүлэх (1) суурь судалгаа /*онолын суурь ШУ-ыг хөгжүүлэх*/, (2) технологийн туршилт, зүгшрүүлэлт /*судалгааны үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх*/-ийн төслийг сонгон шалгаруулж санхүүжүүлнэ.

**Тавигдах шаардлага:**

Төсөл нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Төсөл мэдүүлэх судалгааны багийн удирдагч нь ШУТИС-ийн үндсэн орон тооны (харьяа хүрээлэнгийн судлаачид хамаарна) доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой профессор, багш, судлаач байна;
2. Төслийн багийн гишүүдийн тоог хязгаарлахгүй бөгөөд төслийн багт ШУТИС-ийн үндсэн болон гэрээт профессор багш, судлаач, ажилтан 2 буюу түүнээс дээш, докторын сургалтад хамрагдаж буй нэг оюутныг заавал оролцуулна;
3. Судалгааны төслийг хэрэгжүүлэх хугацаа суурь судалгаа-15 сар, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл-24 сараас хэтрэхгүй байна;
4. Судалгааны үр дүнг эзэмших, ашиглахыг ШУТИС-д зөвшөөрсөн байна;
5. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний үндсэн зорилгод хүрэх замын зураглал-KPI”-ийн үзүүлэлтүүдэд хувь нэмэр оруулсан байна;

№	Төсөлд тавигдах шаардлага:	
	Суурь судалгаа	Технологийн туршилт, зүгшрүүлэлт
1	2	3
1	ШУТИС-ийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд онолын суурь шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шийдвэрлэх асуудал нь тодорхой, оновчтой судалгааны арга замыг сонгосон байх;	Урьд өмнө судлагдсан байх бөгөөд үр дүнгээр оюуны өмчийн эрхийн баталгаажилтын гэрчилгээ авсан байх;
2	WoS, Scopus-т бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлэх;	Судалгааны үр дүнг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээнд туршин нэвтрүүлэх;
3	Дэвшүүлж буй судалгааны чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 1 докторантыг төсөл хэрэгжих хугацаанд урьдчилсан эсвэл жинхэнэ хамгаалалт хийлгэсэн байх;	Төслөөр хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетинг болон бизнес төлөвлөгөөг боловсруулан өрсөлдөх чадвар (зах зээл, үр ашиг, түүхий эд материалын талаарх тооцоо, судалгаа)-ыг илэрхийлсэн байх;



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн  
2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн  
А/157 дугаар тушаалын хавсралт

1	2	3
4	Судалгааны үр дүнд зохиогчийн эрх, ном сурах бичиг, гарын авлагын аль нэгийг гаргах;	Төслийн судалгаа хөгжүүлэлтийн үе шат 6 сар (бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргах), үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх үе шат 18 сар төслийн нийт үргэлжлэх хугацаа 24 хүртэлх сар байх;
5	Судалгааны үр дүнг ШУТИС-ийн багш, судлаачдын дунд хэлэлцүүлж, түгээн дэлгэрүүлэх;	Төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавх (бусад эх үүсвэрээс хамтарсан санхүүжилт авсан бол давуу тал болох)-тай байх;
6	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй 25 сая хүртэлх төгрөг байна.	Төслийн санхүүжилтийн нийт дүн: Эргэн төлөгдөх нөхцөлтэй 50 сая хүртэлх төгрөг байна.

Төслийн материал бүрдүүлэх, төсөл ирүүлэх, шалгаруулах хугацаа:

- Бүрдүүлэх материал: Төсөл санаачлагч баг нь доорх материалыг бүрдүүлэн Эрдэм шинжилгээ, инновацийн газарт ирүүлнэ.
  - Судалгааны баг нь дэвшүүлэх төслийн саналаа "төсөл мэдүүлэх заавар маягт"-ын дагуу боловсруулж, PDF форматаар [research@must.edu.mn](mailto:research@must.edu.mn) цахим хаягаар ирүүлнэ (Материал дутуу ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй);
  - Тухайн судалгааны сэдвийн давтагдаагүй байдал, гарах үр дүнгийн төсөөллийн саналыг төслийн удирдагчийн харьяалах бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн хурлын тэмдэглэл;
- Материал хүлээн авах: Төслийн материалыг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хүлээн авна.
- Төслийн санал хянах: Ирүүлсэн төслийн саналын материал бүрэн эсэх, тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг Эрдэм шинжилгээ, инновацийн газраас хянан магадалгаа хийж, шаардлага хангасан төслүүдийг шалгаруулалтад урина.
- Сонгон шалгаруулах: Шаардлагад нийцсэн төслүүдийг 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн дотор ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлөөр нээлттэй хэлэлцэж, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

Эрдэмтэн судлаач та бүхнийг ШУТИС-ийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/145 дугаар тушаалаар баталсан "ШУТИС-д Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ыг баримтлан, удирдамжийн дагуу төслийн баримт бичгийг боловсруулан, сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.